# БАЯНТАЛ СУМЫН 14 ХОНОГИЙН ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭ

ᠪᠠᠶᠠᠨᠲᠠᠯ ᠰᠤᠮᠤᠨ ᠤ ᠵᠠᠰᠠᠭ ᠤᠨ ᠳᠠᠷᠤᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠲᠠᠮᠠᠭ᠎ᠠ ᠶᠢᠨ ᠭᠠᠵᠠᠷ

ᠪᠠᠶᠠᠨᠲᠠᠯ ᠰᠤᠮᠤᠨ ᠤ 14 ᠬᠣᠨᠣᠭ ᠤᠨ ᠴᠠᠭ ᠤᠶᠡ ᠶᠢᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡ



**2023 оны 08 дугаар сарын 21-ний өдрөөс 09 дүгээр сарын 01-ний хооронд хийгдсэн ажлуудаас**

# УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ:

Засаг дарга , Засаг даргын Тамгын газарт ирсэн, явсан, хариутай албан бичиг, өргөдөл гомдолын шийдвэрлэлтийн талаар:

- 1. **Ирсэн албан бичиг -13**
- -Үүнээс: Бүртгэл хяналтын карт хөтөлсөн хариутай албан бичиг -7
- Хугацаандаа явсан хариутай албан бичиг -3
- Хугацаа хоцорсон -0
- Хугацаа болоогүй-3
- 2. **Явуулсан албан бичиг-11**

3. **Өргөдөл, гомдолын шийдвэрлэлт**

1. **Засаг даргад ирсэн өргөдөл-1**

- **ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР:**

Өмчлөлийн газраа шилжүүлэхийг хүссэн 1 газрын өргөдлийг хүлээн авч шийдвэрлэн гэрээ гэрчилгээг гарган өгч ажилласан.
1 иргэний өргөдлийг хүлээн авч шийдвэрлэсэн.
5 иргэний өмчлөлийн материалыг хүлээлгэн өгсөн.

- 2023 оны 08 дугаар сарын 09-ний өдөр бэлчээрийн газрын фотомониторингийн хээрийн тодруулалтын ажлыг хийсэн.
- 2023 оны 08 дугаар сарын 31-ний өдөр Геодезийн хатуу, цэг тэмдэгтийг хадгалах, хамгаалах ажлын хүрээнд хээрийн хэмжилт тодруулалтыг хийн ажилласан.









# УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ:

Лүн баг 1. 2023.09.01 Орон нутаг хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн 4-р сургуулын хүүхдийн үдийн хоолны 14 ширээ, 96 сандал хүлээж авлаа.





2. 2023.08.30-нд тус багийн нутаг дэвсгэрт автомашинд дайруулсан малын сэг зэмийг, мал эмнэлэгийн мэргэжилтэнтэй хамтарч ариутгал хийж булж устгалд оруулсан.





3. 2023-2024 оны хичээлийн шинэ жилийг угтан байгууллага, аж ахуй нэгжүүд нийтийн ойр орчмыг цэвэрлэх ажил хийгдлээ. Багийн мэдээ мэдээллийг 758 хүнд цаг алдалгүй цахимаар игэдэд мэдээллэж ажиллаж байна.





# УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ:

Их Уул баг

Үндэсний статистикийн хорооноос ирүүлсэн амьдрах орчны аюулгүй байдлын судалгааны тодруулга Их Уул багийн хэмжээнд 20 өрхийн нэр ирсэн. Энэхүү тодруулгыг 2023 оны 08 дугаар сарын 15-аас эхлүүлэн 08 дугаар сарын 25-ны өдрийн хооронд хийж дамжуулсан.





# Санхүү төсөв: 2023 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах талаар

Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн 06 дугаар тогтоолоор сумын 2023 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулан 1,837,938.1 мянган төгрөгөөр өөрчлөгдөн батлагдсан байна. Үүнд ЕБС, СӨБ, ЗДТГ-ын тогтмол зардалд 31,000.0 мянган төгрөг, Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ны өдрийн 241 дүгээр тогтоолоор ЗДТГ-т 62,600.0 мянган төгрөгийг цалин болон ндш, ИТХ-д 9,100.0 мянган төгрөгийг цалин болон НДШ, Мөн ЗДТГ-т нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардалд 2,104.0 мянган төгрөг, тээвэр шатахуунд-1,500.0 мянган төгрөг, бичиг хэргийн зардалд 396.0 мянган төгрөг нийт 106,700.0 мянган төгрөгийн сумын төсөвт нэмэлт өөрчлөлт орууллаа.









# Санхүү төсөв: 8 сарын орлогын бүрдүүлэлтийн талаар

2023 оны 08 дугаар сарын 31-ний байдлаар 101.975.3 мянган төгрөг төлөвлөгөө батлагдсанаас гүйцэтгэлээр 104,944.3 мянган төгрөг буюу 102.9 хувиар орлогыг давуулан биелүүлсэн байна.

Баянтал сумын нэгтгэлийн/ОН/ төлөвлөгөө 1,181,205.5 мянган төгрөг, гүйцэтгэл 870,357.8 мянган төгрөг байна. Үүнээс үндсэн цалин,унаа хоол,нэмэгдэл урамшуулалд 271,981.1 мянган төгрөг НДШ 34,307.8 мянган төгрөг зарцуулсан байна.

Баянтал сумын нэгтгэлийн /ОН/ өглөг 1,952.0 мянган төгрөг , авлага 3,758.5 мянган төгрөг байна. Төсвийн тодотголоор цэвэр бохир усны төлбөр, гэрэл цахилгааны төлбөрийг 100 хувь барагдуулан ажиллаа.

**2023 оны 8 сарын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл**



# ХОРШОО ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН ТАЛААР:

- Хоршоо хөгжүүлэх сангийн орлого 43 сая төгрөг. Жилийн орлогын төлөвлөгөө 40 сая төгрөг. Биелэлтийн хувь 107,5%
- ХХСан нь 8 зээлдэгчийн 170,981,898.00 төгрөгийн үлдэгдэлтэй байна. Үүнээс:

➢ 2022 онд олгосон 94,057,342.00 төгрөг

➢ 2021 оны 2 зээлдэгчийн 47,614,559.00 төгрөгийн үлдэгдэл / хугацаа хэтэрсэн зээл /

➢ 2015 оны 1 зээлдэгчийн 12,932,475.00 төгрөгийн үлдэгдэл /муу зээл/

➢ 2013 оны 4 зээлдэгчийн 16,377,522.00 төгрөгийн үлдэгдэлтэй байна. / муу зээл /

- Хүрсэн түвшин:
- 8 Зээлдэгчийн мэдээлэл Монгол банкинд 100 % холбогдсон.
- 4 зээлдэгчийн 23,791,266 төгрөгийн зээл барагдсан .

# БАЙГАЛЬ ОРЧИН :

Сумын засаг даргын 2023 оны 08 дугаар сарын 30-ний өдрийн 279 тоот албан бичгийг суманд үйл ажиллагаа явуулж байгаа 17 ААН, албан байгууллагуудад хүргүүлж хуваарьт газруудын цэвэрлэгээг цэгцэлгээг хийлгэж ажилласан.

1 тн хөнгөн өвс 2 малчин өрхөд хүлээлгэн өгсөн.








# ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ:

## Амбулаторийн үйлчилгээ:

- Нийт үзлэг-72
- Амбулаторийн үзлэг -64
- Үүнээс:
- Идэвхитэй хяналт -3
- Өдрийн эмчилгээ-2
- Гэрийн эмчилгээ-8

Урьдчилан сэргийлэх үзлэг- 45

## Түргэн тусламжийн дуудлагын төрөл, тоо хэмжээ:

- Нийт дуудлага -15
- Алсын дуудлага -4
- Төвийн дуудлага -11
- Том хүн -11
- Хүүхэд-4
- Осол гэмтэл-0

## Стационарийн үйл ажиллагаа:

- Хэвтэн эмчлүүлэгчид нийт-8
- Дотор -8
- Хүүхэд -0
- Халдварт-0

**Лабораторийн үзлэгийн тоо: 79 /давхардсан тоо/**






Сургууль, цэцэрлэг орохтой холбогдуулан цэцэрлэг болон дотуур байрны хүүхдийг цагаан хорхойн шинжилгээг 89 хүүхдээс авлаа

# ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ТАЛААР:

1. Жил бүр сумдын ОНХС-ийн үйл ажиллагааг үнэлдэг “Жилийн гүйцэтгэлийн үнэлгээ” /ЖГҮ/ 2023 оны 8 дугаар сарын 27-ны өдөр үнэлүүлэв. Энэ жилийн хувьд өмнөх жилүүдийн адилаар “олон нийтийн оролцоо”, “төлөвлөлт”, “ил тод байдал”, “хэрэгжилт”, “хяналт, шинжилгээ-үнэлгээ”, “өмчлөл” гэсэн 6 бүлгийн нийт 35 үзүүлэлтээр ОНХС-ийн үйл ажиллагааг үнэлэв. Мөн ОНХС-гийн талаар Фокус ярилцлага өгөв.

2. 2023 оны 08 дугаар 31-ний өдрийн А/91 дугаар захирамжаар байгуулагдсан ажил хүлээн авах комисс нь “сургуулийн үдийн хоолны ширээ сандал хийх” ажлыг 2023 оны 09-р сарын 01-ний өдөр хүлээн авлаа.











# ХӨДӨӨ АЖ АХУЙН ТАЛААР:

**Намаржилтын ерөнхий нөхцөл байдал:**
Энэ намар 88 малчин, 72 мал бүхий өрхийн 72035 толгой мал намаржиж байна. 2023.09.04 байдлаар 0.5 га талбайгаас 0.2 тн төмс, 1.2 тн хүнсний ногоо хураан авсан дүнтэй байна. Малчин өрхүүдэд шаардлагатай өвс тэжээлийн хуваарийг гарган хүргүүлж байна. Сумын агропаркийн худгийг засварлан ашиглалтад оруулсан. Мөн агропаркийн хуучин хашааг засварлан цаг уурын тандалтын хашааг шинээр барьсан. Хоёр малчин Төв, Хэнтий аймагт хадлан хадах гэрээ байгуулан техник засварын ажлаа эхлээд байна. Хөдөлмөр халамж үйлчилгээний газартай хамтран 6 иргэнийг 10 хоног түр ажлын байраа хангасан.

**Малчдад үзүүлж буй нийгэм, эрүүл мэндийн үйлчилгээ:**
Малчдад худалдаа, үйлчилгээ, шатах тослох материал зардаг ШТС, эрүүл мэндийн төвийн эмч эмнэлэгийн ажилтнууд тухай бүрд нь үйлчилгээ үзүүлж байна. Мөн эмийн сангийн үйлчилгээ, төрийн Е-Монгол хур системийн бүх төрлийн лавлагааны үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна.

**Малын өвчний байдал, тайван эсэх:**
Одоогоор малын өвчлөл гараагүй тайван байна.Малын өвчнөөс сэргийлэх талаар Баянтал ХААТ группэд 2 удаа сэрэмжлүүлэг хүргэсэн.





4.Сургуулийн урлаг, спорт заал 00-той болсон
5.Хичээлийн шинэ жил эхлэхтэй холбоотойгоор сургуулийн цэвэрлэгээг хийж гүйцэтгэж байна.

# БОЛОВСРОЛЫН ТАЛААР:

## ЕБСургууль:

1.Баянтал сумын ЕБСургуулийн сургуулийн дотуур байрны өрөөнүүдийн эвдэрсэн эд зүйлсийг засан сэлбэх, хүүхэд хөгжлийн өрөөний дотор засварыг хийж гүйцэтгэлээ.

2. Сургуулийн спорт заалны үүдний өрөөг засварлалаа.

3.Сургуулийн үүдний тамбарын дээврийг засварлаж, борооны ус нэвтрэхээс хамгаалсан.

4.Сургуулийн урлаг, спорт заал 00-той болсон.

5.Хичээлийн шинэ жил эхлэхтэй холбоотойгоор сургуулийн цэвэрлэгээг хийж гүйцэтгэж байна.

6.Сургуулийн хашааны хөл газрын ургамлыг түүж, цэвэрлэсэн.

7.Спорт заалыг засварлах, ханыг будах ажлыг хийж гүйцэтгэж байна. 3.Баянтал сумын ЕБС нь өнөөдрийн байдлаар esis.edu.mn 154 сурагч бүртгэлтэй байгаа бөгөөд энэ хичээлийн жилд хамран сургах тойргоороо 1-р ангид шинээр элсэх 17 сурагчтай, урьдчилсан байдлаар 171 суралцагчтай хичээл сургалтын үйл ажиллагаа явуулах тооцоололтой байна.








# БОЛОВСРОЛЫН ТАЛААР: ЦЭЦЭРЛЭГ

**Сургуулийн өмнөх боловсрол нь:**

1. 2023-2024 оны хичээлийн жилд 2-5 насны 75 хүүхэд бүртгэлтэйгээс 60 хүүхэд хамрагдсанаар хүүхдийн хамрагдалтын хувь 80%-тай байна.
2. 2023 оны 08 дугаар сарын 17-19-ны өдрүүдэд "Бага насны хүүхдийн цогц хөгжил" сургагч багш бэлтгэх сургалтанд 2 бүлгийн багш, 2023 оны 08 дугаар сарын 22-26-ны өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгуулагдсан "Боловсролын шинэ сэргэлт-сургуулийн өмнөх боловсрол" сургалт-семинарт эрхлэгч нар тус тус хамрагдсан байна.
3. 9.1-ны хичээлийн шинэ жилийн нээлтийн үйл ажиллагаанд сумын Засаг дарга, сумын Тамгын газрын дарга, сумын Засаг даргын орлогч, ахмад багш нар хүрэлцэн ирж оролцсон. Мөн аймгийн Засаг дарга, БШУГ-н дарга нар байгууллагын үйл ажиллагаатай танилцаж багшийн хөгжлийг дэмжин зөөврийн компьютер гардуулан өгсөн.
4. Сумын ИТХ-н хөрөнгөөр СӨБ байгууллагад хөрөнгө оруулалт хийн 13,613,000 төгрөгний үнэ бүхий 3 бүлгийн тоглоом, 4,700,000 төгрөгний үнэ бүхий гал тогооны тоног төхөөрөмжийг хүлээлгэн өгсөн байна.








# СОЁЛ УРЛАГИЙН ТАЛААР:

“Нүүдэлчин” ДЭЛХИЙН СОЁЛЫН ФЕСТИВАЛЬ

“Нүүдэлчин” ДЭЛХИЙН СОЁЛЫН ФЕСТИВАЛЬД Баянтал сумаас 2 ардын авьяастан хөх тэнгэрийн нүүдэлчид, боржигин найрын дэг тоглолтонд оролцсон бөгөөд тус наадмын үеэр Соёлын төвийн дуу хөгжмийн багш о.Бадамцэцэг Монгол улсын соёлын тэргүүний ажилтан шагналаар шагнагдсан.





# “Нүүдэлчин” ДЭЛХИЙН СОЁЛЫН ФЕСТИВАЛЬ

“Нүүдэлчин” ДЭЛХИЙН СОЁЛЫН ФЕСТИВАЛЬД ХАМТ ОЛНООРОО ОРОЛЦОЖ Боржигин тоглоом наадгайн БОЛОВСРОЛЫН АЖЛЫГ хариуцан зохион байгууллаа.






# “Нүүдэлчин” ДЭЛХИЙН СОЁЛЫН ФЕСТИВАЛЬ

“Нүүдэлчин” ДЭЛХИЙН СОЁЛЫН ФЕСТИВАЛЬД соёлын бүтээлч үйлдвэрлэлийн үзэсгэлэн худалдаанд оролцлоо.






# “Нүүдэлчин” ДЭЛХИЙН СОЁЛЫН ФЕСТИВАЛЬ

“Нүүдэлчин” ДЭЛХИЙН СОЁЛЫН ФЕСТИВАЛьд оролцогчдын арын албанд  хуваарийн дагуу хоол хийх, гэр ачих, буулгах, барих, тохижуулах ажилд хамтран ажиллаа .






# ТАЛЫН ИЛЧ ОНӨААТҮГазар :

| № | Хийгдэх ажлууд | Хэрэгжилт | Хувь |
|---|---|---|---|
| | **1. Уурын зуух** | | |
| 1.1 | 1-р зуухны гадна талын битүүмж төмрийг сольж дулаалга хийх, зуухны аманд засвар хийх | 1-р зуухны гадна талын төмрийг сольж дулаалан галлагаа эхлэхэд хэвийн болгон засварласан. | 100% |
| 1.2 | 2-р зуухны янданг буулгаж, муудсан хэсгийг сольж сэргээн засварлах | Ажиллах хүчтэй холбоотой 8-р сард хийхээр хугацааг хойшлуулсан байна | Биелэлтийн 2-2д |
| 1.3 | Нүүрс нөөцлөх талбайн цөмөрч муудсан зам талбайг засварлаж бетон цутгах | Уурын зуухны хашаанд байрлах нүүрс нөөцлөх талбайг засварлаж бетон цутгасан. | 100% |
| 1.4 | Зуухны гэрэлтүүлгийн монтажыг сэргээн засварлах | Зуухны гэрэтүүлгийн монтажыг засварлаж, ашиглаж буй гэрлүүдэд засвар хийсэн. | 100% |
| 1.5 | Нүүрс татан авалт 80тн /9 сарын эхэнд татах/ | Нүүрс татан авах талбайг засварлан, машин техникийн бүрэн бүтэн байдлыг хангасан. | 50% |

| 2. Байгууллагын гадна тохижилт, ногоон байгууламж нэмэгдүүлэх | | |
|---|---|---|
| Конторын барилгын гадна талын нүүрийг шавар хийж хар замаск татан өнгө оруулан будах | 6-р сард бүрэн хийгдэж дууссан. Нийт 4,5 сая төгрөг зарцуулсан. | 100% |
| Конторын гадна 8 автомашины зогсоол шинээр хийх | 6-р сард хийж дууссан. 2,3 сая төгрөг зарцуулсан. | 80% |
| Байгууллагын гадна талбайд 250 ширхэг хайлаас мод болон зүлэг тарих | 6-р сард бүрэн хийж дууссан 650,0 мянган төгрөгөөр суулгац худалдан авсан | 100% |

| 3. Цэвэр болон бохирын худгуудад хийх ажлууд | | |
| --- | --- | --- |
| Сүлжээний насосд үйлчилгээ засвар хийх | Сүлжээний насосд засвар үйлчилгээ хийсэн. | 100% |
| Бохирын насос станцад урсгал засвар хийх | Бохирын насос станцад урсгал засварыг 8-р сард хийсэн. | 100% |
| Цэвэр усны худгуудын барилга болон насосд урсгал засвар хийх | Цэвэр усны худгуудын барилга болон насосд урсгал засвар хийсэн. | 100% |
| Хуучирч муудсан цэвэр усны шугам 159-н 20 метр шугам шинэчлэн солих | Хугацаа болоогүй | |
| 154-р байрны подволын дулаан цэвэр усны шугамыг шинэчлэн солиулах | Орон нутгийн хөрөнгө оруулалтаар бүрэн хийгдэж дууссан. | 100% |
| 105, 152-р байрны подволын шугам хоолойд засвар хийж шаардлагатай хаалт винтелийг солих | 6-р сард муудсан хаалт, винтелийг сольж засварласан. | 100% |
| Бохирын хаялагын цэгийн хамгаалах тор шонг сэргээн засварлах | 5-р сард тасарсан тор, шонг нөхөж засварласан. 210,0 төгрөг зарцуулсан. | 100% |
| Бохирын худгуудыг лайдаж цэвэрлэх | Хугацаа болоогүй | Биелэлтийн 2-2д |
| Бохир /КНС/-н лагийг ухаж цэвэрлэх | Хугацаа болоогүй | Биелэлтийн 2-2д |
| Цэвэр ус болон дулааны худгуудад урсгал засвар хийж шаардлагатай тохиолдолд хаалт винтелийг солих | 6-р сард хийгдсэн. 560,0 мянган төгрөг зарцуулсан. 5ш хаалт сольсон. | 100% |
| **Нийт ажлын гүйцэтгэлийн хувь** | | **78,2%** |



**МЭДЭЭНИЙ ЭХИЙГ БЭЛТГЭСЭН ЗДТГАЗРЫН ДАРГА Ц.ЛХАГВАДОНИД**